

МАЛ, АМЬТНЫ ТЭЖЭЭЛ ҮЙЛДВЭРЛЭХ, ИМПОРТЛОХОД ТАВИГДАХ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ШААРДЛАГА

Нэг. Нийтлэг үндэслэл

1.2 Мал, амьтанд зориулан үйлдвэрлэх, импортлох тэжээл, тэжээлийн нэмэлтийн аюулгүй байдалд тавих шаардлагыг (цаашид Техникийн зохицуулалтын шаардлага гэх) малын тэжээл бэлтгэх зохистой дадал САС/RCP 54-2004 олон улсын кодекс стандарт, Монгол Улсын “Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай”, “Хүнсний тухай”, Мал, амьтны эрүүл мэндийн тухай, “Малын генетик нөөцийн тухай”, “Улсын нөөцийн тухай” хуулиудад нийцүүлэн боловсруулсан болно.

1.3 Техникийн зохицуулалтын шаардлага нь тэжээл, тэжээлийн нэмэлт үйлдвэрлэх, тээвэрлэх, хадгалах, борлуулахад оролцдог иргэн, хуулийн этгээд, тэдгээрийн аюулгүй байдлын хяналтыг хэрэгжүүлдэг төрийн байгууллагууд, тохирлыг нь үнэлдэг (баталгаажуулдаг) лаборатори болон итгэмжлэдэг байгууллагуудын үйл ажиллагаанд хамаарна.

1.3. Мал, амьтны тэжээл үйлдвэрлэх, импортлоход тавих аюулгүй байдлын хяналтыг дараах үе шаттайгаар явуулна.

- 1) тэжээл ба тэжээлийн нэмэлт худалдан авах;
- 2) тэжээл ба тэжээлийн нэмэлт үйлдвэрлэх; шинжлэх
- 3) тэжээл, тэжээлийн нэмэлтийг тээвэрлэх, хадгалах;
- 4) тэжээл ба тэжээлийн нэмэлтийг ашиглах, устгах.

1.4. Тэжээл, тэжээлийн нэмэлтийн онцлогоос хамааран аюулгүй байдалд дараах хяналт, үнэлгээг хийнэ. Үүнд:

1.4.1. Тэжээл ба тэжээлийн нэмэлт бүтээгдэхүүний баримт бичгийг шалгах;

1.4.2. Тэжээл ба тэжээлийн нэмэлтээс дээж авах, бие даасан итгэмжлэгдсэн лабораторид явуулах, шинжилгээ хийлгэх;

1.4.3. Тухайн бүтээгдэхүүнээр мал, амьтан тэжээж туршсан үр дүнг шалгах.

Хоёр. Нэр томъёо, тодорхойлолт

2.1 Энэхүү Техникийн зохицуулалтад дараахь нэр томъёо, тодорхойлолтыг ашигласан болно.

2.1.1. Тэжээл ба тэжээлийн нэмэлтүүдийн аюулгүй байдал- —тэжээл, тэжээлийн нэмэлтүүдийн түүхий эдийг бэлтгэх, боловсруулах, үйлдвэрлэх, хүлээн авах, худалдах, ашиглах, устгах бүхий л үе шатад эрсдэл учруулахгүй байх нөхцөл;

2.1.2. Тэжээл – Мал, амьтан тэжээхэд ашигладаг, шимт бодисуудыг агуулсан, эрүүл мэндэд нь хортой нөлөө үзүүлдэггүй, ургамал, амьтан, эрдэс, микробиологи, химийн гаралтай бүтээгдэхүүн;

2.1.3. Тэжээлийн нэмэлт – Мал, амьтны бие махбодын үйл ажиллагааг дэмжих, зохицуулах болон тэжээлд амт, үнэр, өнгө оруулах, биежүүлэх, сийрэгжүүлэх, хадгалах хугацааг уртасгах, технологи ажиллагааг хурдасгах үйлчилгээ бүхий дан болон олон найрлагат бэлдмэл;

2.1.4. Хадгалах хугацаа- Өгөгдсөн хугацаанд зохих нөхцөлийн дагуу хадгалж, хэрэглэхэд тухайн бүтээгдэхүүний чанар хамгийн сайн түвшинд байх, тухайн хугацаа

хэтрэхэд бүтээгдэхүүний аюулгүй байдал нь алдагдахгүй боловч чанарын үзүүлэлт нь муудах буюу өөрчлөгдөх хугацаа;

2.1.5. Хэрэглэж дуусах хугацаа- өгөгдсөн хугацаанд тухайн бүтээгдэхүүн аюулгүй байх, энэ хугацаа өнгөрөхөд аюулгүй байдал нь алдагдах хугацаа;

2.1.6. Эрсдэл – Мал, амьтны эрүүл мэндэд тэжээл, тэжээлийн нэмэлтүүд аюул учруулах сөрөг нөлөө үзүүлэх магадлал, нөлөөллийн үр дагавар;

2.1.7. Хоруу чанар - Тэжээл ба тэжээлийн нэмэлтэд мал, амьтныг өвчлүүлэн, үхэлд хүргэж болзошгүй хорт бодисын агууламж зөвшөөрөгдөх хэмжээнээс илүү байх шинж чанар.

Гурав. Монгол улсад Тэжээл ба тэжээлийн нэмэлтүүдийг үйлдвэрлэхэд тавигдах аюулгүй байдлын шаардлага

3.1. Тэжээл болон тэжээлийн нэмэлт үйлдвэрлэх байгууламж нь стандартын шаардлагыг хангасан түүхий эд хадгалах, тэжээл, тэжээлийн нэмэлт үйлдвэрлэх, хадгалах зориулалтын тусдаа өрөөнүүдтэй байх ба шувуу, мэрэгчид, шавж нэвтрэхээс хамгаалагдсан байх;

3.2. Бүтээгдэхүүн бохирдохоос сэргийлэх нөхцлийг бүрдүүлж, био бүтээгдэхүүн үйлдвэрлэх цехийг тусдаа байраар хангах;

3.3. Тэжээлийн үйлдвэрт гарч болзошгүй гэнэтийн осол, аюулаас урьдчилан сэргийлэх зорилгоор техник тоног төхөөрөмжийг зааврын дагуу байрлуулж, хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн шаардлагыг бүрэн хангасан байх;

3.4. Тэжээлийн жорын найрлагад тохирсон түүхий эдээр стандартад нийцсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх зориулалтын тоног төхөөрөмж ашиглах, жин, хэмжих хэрэгслүүд нь тохиргоо хийгдсэн байх ба нарийвчлалыг тогтмол шалгадаг байх;

3.5 Тэжээлийн түүхий эдийг хүлээн авах, боловсруулах, үйлдвэрлэх, хадгалах, тээвэрлэх зэрэг бүх үе шатанд бүтээгдэхүүн муудах эрсдэл үүсэхээс хамгаалах;

3.6. Тэжээл, тэжээлийн нэмэлтүүдийг үйлдвэрлэхэд цацраг идэвхт бодис эсвэл хүнд металлын давсны агууламж ихтэй геохимийн бүсүүдийн ойролцоо тэжээлийн түүхий эдийг бэлтгэхгүй байх;

3.7. Чанар, ариун цэврийн шаардлага хангаагүй, хуурамч түүхий эд, баглаа боодлын материал ашиглахгүй байх;

3.8 Тэжээлийг энэхүү шаардлагын нэгдүгээр хавсралтад заасан стандарт болон холбогдох технологийн зааврыг баримтлан үйлдвэрлэх;

3.9 Тэжээл үйлдвэрлэл болон хадгалах явцад хордлого үүсгэх эмгэг төрүүлэгч бичил биетэн үржих, хорт бодис хуримтлагдах нөхцлийг бүрдүүлэхгүй байх, мэрэгч, шавжны эсрэг бодис, консервантуудыг зүй бусаар ашиглахгүй байх;

3.10 Түүхий эд бүтээгдэхүүний хоруу чанарыг төлөвлөгөөтэйгөөр тодорхойлуулдаг байх;

3.11 Монгол улсын нутаг дэвсгэрт үйлдвэрлэсэн болон импортолсон тэжээл, тэжээлийн нэмэлтийг тогтоосон журмын дагуу улсын бүртгэлд хамруулах;

3.12 Тэжээлийн чанар аюулгүй байдлын шаардлагыг хангах зорилгоор хяналтын систем нэвтрүүлсэн байх;

3.13 Ажилтан нь тэжээл үйлдвэрлэлийн чиглэлээр мэргэшсэн, мэргэжлийн сургалтуудад хамрагдсан байх.

Дөрөв.Тэжээлийн савлагаа, шошгонд тавигдах шаардлага

4.1. Тэжээл, тэжээлийн нэмэлтийн шошгонд хэрэглэгчдэд зориулсан дараах мэдээллийг зайлшгүй тусгана;

4.1.1. үйлдвэрлэгчийн албан ёсны нэр, хаяг;

4.1.2. үйлдвэрлэсэн он, сар, өдөр;

4.1.3. стандартын тэмдэглэгээ;

4.1.3. тэжээлийн зориулалт, тэжээлийн шимт чанар, орц найрлагын мэдээлэл;

4.1.4. Хэрэглэх болон хадгалах хугацаа, нөхцөл;

4.1.5. тэжээлийн хэрэглээний талаар нэмэлт заавар;

4.2. Тэжээлийн шошгыг монгол хэл дээр үйлдэнэ;

4.3. Шошгонд хэрэглэгчдийг төөрөгдөлд оруулах үг хэллэг хэрэглэхийг хориглоно;

4.4. Хаяг шошго нь гадны хүчин зүйлсийн нөлөөгөөр гээгдэхгүй, бат, бөх байна;

Тав. Тэжээл, тэжээлийн нэмэлтийн чанар, аюулгүй байдлын тохирлыг хянах

5.1 Тэжээл, тэжээлийн нэмэлтийн тохирлыг шалгах ажлыг Монгол улсын хууль, тогтоомжийн шаардлагын дагуу дараах байдлаар явуулна. Үүнд:

5.1.1. Тэжээл, тэжээлийн нэмэлтийг үйлдвэрлэгчийн нэр, бүтээгдэхүүний нэр, зориулалт, сав баглаа боодол дээрх шошго, эсвэл гарал үүслийг баталгаажуулсан баримт бичиг, тохирлын гэрчилгээ эсвэл тохирлын тэмдэг, тохирлын мэдүүлэг;

5.2 Тэжээл, тэжээлийн нэмэлтийн стандартад заагдсан үзүүлэлтүүд тохирч байгаа эсэхийг шалгах ;

5.3 Бүтээгдэхүүний гадаад шинж чанарыг мэдрэхүй эрхтний тусламжтайгаар үнэлэн харьцуулах

5.4 Бүтээгдэхүүний физик, хими, микробиологийн үзүүлэлтүүдийг мэдрэхүйн аргуудаар тогтоох боломжгүй бол багажит шинжилгээний аргаар үнэлэх

5.5 Бүтээгдэхүүнийг үйлдвэрлэсэн огноо, хадгалах хугацаа, нөхцөл болон ерөнхий болон тусгай тэмдэглэгээг хянах;

5.6 Бүтээгдэхүүнд хийсэн магадлан итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээний дүн, үзүүлэлтүүдийг хянах;

5.7 Бүтээгдэхүүний сав баглаа боодлын төрөл,бүтээгдэхүүний хэмжээ, багцын дугаарыг хянах

Зургаа. Тэжээл, тэжээлийн нэмэлт импортлоход тавих аюулгүй байдлын шаардлага

6.1 Монгол Улсаас гадаад улстай амьтан, ургамлын хорио цээрийн талаар байгуулсан хэлэлцээр, Монгол Улсын нэгдэн орсон гэрээ, конвенцид.заасан гэрээ, үүрэг, зөвлөмжийн нөхцлийг мөрдсөн байх;

6.2 Монгол Улсын нутаг дэвсгэрт импортлох тэжээл, тэжээлийн нэмэлт нь улсын бүртгэлд бүртгэгдсэн байх ба энэхүү техникийн зохицуулалтын шаардлагыг хангасан байх;

6.3 Импортлох тэжээл, тэжээлийн нэмэлт нь Монгол улсын болон үйлдвэрлэгч улсын стандартын шаардлагад нийцсэн байх.

Долоо. Тэжээлийг хадгалах, тээвэрлэхэд тавих аюулгүй ажиллагааны шаардлага

7.1 Тухайн нэр төрлийн тэжээл, тэжээлийн нэмэлтийн чанарыг алдагдуулахааргүй, тэжээлийн онцлогт тохирсон орчинд нарны шууд тусгалгүй хуурай сэрүүн нөхцөл хангасан агуулах, саванд хадгалах;

7.2 Тэжээл, тэжээлийн нэмэлтийг түлш, тослох материал, хүнсний бүтээгдэхүүнтэй хамт хадгалах, тээвэрлэхийг хориглох.

Найм. Тэжээл ба тэжээлийн нэмэлтүүдийг хэрэглээнээс хасах, устгах нөхцөл

8.1 Монгол Улсын хууль тогтоомжийн шаардлагад нийцээгүй;

8.2 Гарал үүсэл болон аюулгүй байдлыг баталгаажуулсан баримт бичиггүй, хугацаа нь дууссан, шошгогүй;

8.3 Дагалт баримт бичигт тусгагдсан мэдээлэлтэй тохирохгүй тэжээл, тэжээлийн нэмэлт;

8.4 Тааламжгүй үнэртэй болсон, муудаж, бохирдсон илэрхий шинж тэмдэг илэрсэн.

МОНГОЛ УЛСАД МӨРДДӨГ ТЭЖЭЭЛ, ТЭЖЭЭЛИЙН НЭМЭЛТЭД ТАВИГДАХ
СТАНДАРТУУДЫН ЖАГСААЛТ

- “Өвс MNS 0592:2008”
- “Буудайн хивэг. техникийн шаардлага MNS 0961:2008”
- “Малын нэмэгдэл тэжээл. техникийн шаардлага MNS 1077:2008”
- “Үр тарианы хаягдал. техникийн шаардлага MNS 1080:2008”
- “Тэжээлийн үр тариа. техникийн шаардлага MNS 1081:2008”
- “Төлийн бүрэн найрлагат багсармал тэжээл. техникийн шаардлага MNS 2607:2008”
- “Амьтны гаралтай уурагт тэжээлийн гурил. техникийн шаардлага MNS 0547:2008”
- “Дарш. техникийн шаардлага MNS 3466:2008”
- “Өвсөн дарш. техникийн шаардлага MNS 3467:2008”
- “Үхрийн хүчит багсармал тэжээл. техникийн ерөнхий шаардлага MNS 5928:2008”
“Тахианы бүрэн найрлагат багсармал тэжээл. техникийн ерөнхий шаардлага MNS 5929:2008”
- “Тахайн бүрэн найрлагат багсармал тэжээл. техникийн ерөнхий шаардлага MNS 5930:2008”
- “Тугал угжих багсармал тэжээл MNS 4091:1988”
- “Хужир MNS 1082:1973
- “Эрдэс нэмэгдэл тэжээл MNS 1083:1970”
- “Малын тэжээлийн давс MNS 1786:1973
- “Шүү MNS 1787:1973”
- “Уурагт тэжээл MNS 2600:1978
- “Сүрлэн дарш MNS 9470:1983”
- “Төрөл бүрийн шимт тэжээл 4550:1998”
- “Рапсын шахдас. Техникийн шаардлага MNS GB 22514 : 2015”

-----o0o-----